

Орхон аймгийн ИЗНН-ын хороо

Орхон аймгийн ИЗНН-ын хорооны тэргүүлэгчдийн хурлын
2020 оны 05 дугаар ёарын -ны өдрийн дүгээр тогтоолын
Нэгдүгээр хавсралт

ОРХОН АЙМГИЙН ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМЫН ХОРООНЫ “УРИА”

“ТАНЫ ИТГЭЛ- БИДНИЙ ЗҮТГЭЛ САЙХАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ”

Орхон аймгийн ИЗНН-ын хорооны аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Сонгуульд оролцох 2020 оны МӨРИЙН ХӨТӨЛБӨР:

Зорилго

Иргэний зориг ногоон нам нь хүн төрөлхтний бүтээлч үнэт зүйлсийг дээдэлсэн, уламжлал шинэчлэлийн /консерватив/ үзэл баримтлалтай, төвийг сахисан, улс төрийн чиг баримжаатай, Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг улс төрийн хүчин юм. Иргэний зориг ногоон нам нь “Шинээр сэтгэж, шинээр хийх” зарчим дээр тулгуурласан шинэ үзэл санааны нам бөгөөд Орхон аймгийн ИЗНН-ын хорооноос аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо “Төрд шударга зүтгэсэн хэнийг боловч түмний удирдагч болго” гэсэн их эзэн Чингис хааны захиасыг мөрдлөг болгож, Орхон аймаг болон орон нутгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй хотод амьдрах боломжийг бүрдүүлэх “ТАНЫ ИТГЭЛ-БИДНИЙ ЗҮТГЭЛ САЙХАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ” МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР САНАЛ БОЛГОЖ БАЙНА.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1.1. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад зах зээлд эрэлт хэрэгцээ ихтэй байгаа мэргэжлээр сурч, мэргэших хүсэл сонирхолтой залуучуудтай тодорхой гэрээ, хэлцэл /контракт/ байгуулж ажиллана.

1.2. Бүс нутгийн газар зүйн байршил, онцлог, давуу тал дээр түшиглэсэн Монгол үндэсний соёлын биет болон биет бус өвийг хойч үедээ өвлүүлэх, хадгалан хамгаалах зорилгоор аймгийн доторх түүхт хөшөө, дурсгалт газруудыг сэргээн засварлаж гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэн орон нутгийн эдийн засагт нөлөөлөхүйц салбар болгож хөгжүүлнэ.



1.3. Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бүс нутгийн МСҮТ боловсон хүчний сургалт дадлагажилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

1.4. Нийтийн үйлчилгээ болон зорчих тээврийн орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж тэдэнд ээлтэй, хүртээмжтэй байх талаар анхаарч ажиллах.

ХОЁР. ЦАЛИН ХӨЛС, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРЭЭНД

2.1. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАЛ”, “ЗӨВ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.2. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн чанар хүртээмжийг сайжруулж эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдын ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэх бодлого барьж ажиллана.

2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах төвүүдийг аймагт байгуулах ажлыг эхлүүлэх.

ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО, ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР

3.1. Бүх шатанд авилга, хээл хахуультай хийх тэмцлийг эрч хүчтэй өрнүүлж, авилга хээл хахуулийн талаарх суртлыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулж, хүнд суртал, шат дамжлагыг арилгаж, хариуцлагагүй байдлаас ангижруулан чирэгдэлгүй болгож, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгоно.

3.2. Хүнсний ногоо, газар тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

3.3. Малчид, газар тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг иргэд, худалдан авагчдын гар дээр илүү шат дамжлагагүй /ченжгүй/-ээр шууд очих боломжийг бүрдүүлж ажиллана.

ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1. Эрдэнэт хотын агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлэх



4.2.Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хог хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,

4.3. Гэр хорооллын айл, өрхүүдийг төвийн дулаан ,цэвэр, бохир усанд холбогдох, цахилгаан зуух ашиглах нөхцөл , боломжийг бүрдүүлэх нэмэгдүүлэх замаар аймгийн агаарын бохирдлын асуудлыг цогцоор нь шийдвэрлэж иргэдийн амьдрах орчинг сайжруулан эрүүл мэндийг нь хамгаалах ,байгаль орчны судалгаа, шинжилгээний ажлын тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.

4.4.Хот ,гэр хорооллын хог хаягдлыг зайлуулах үр дүнтэй систем нэвтрүүлнэ.

4.5. Томоохон төвлөрсөн үйлчилгээний байгууллагуудыг авто машины зогсоолтой болгож ,авто замын түгжрэлийг багасгах ажлыг хэрэгжүүлнэ.

ЭРХЭМ ХҮНДЭТ ИРГЭД ЭЭ !
ТӨРӨЛХ НУТГИЙНХАА ЭЗЭН НЬ БАЙЖ АЙМАГТАА
ТЭГШ ЭРХТЭЙ ХАНГАЛУУН ЖАРГАЛТАЙ АМЬДАРЦГААЯ!
ОРХОН АЙМГИЙН ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН НАМ

ОРХОН АЙМГИЙН ИРГЭНИЙ ЗОРИГ НОГООН
НАМЫН ХОРООН ДАРГА.....



..... Б.БАТ-ЭРДЭНЭ

